

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Тоног төхөөрөмжийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хөрөнгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2021-02-05		ЗТ-21/02-014	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Галын, байгалийн, сантехникийн					
	Даатгалын үндсэн эрсдэл	Цахилгаан эрчим хүч, 3 дагч этгээд, ахуйн, хулгайн дээрэм					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.2%-1.5%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД**

1. Даатгалын зүйлийн ердийн элэгдэл, хорогдол зэрэг тоног төхөөрөмжийн шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;

2. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх, ашиглалтын горим зааврыг зөрчсөн болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
3. Галын дүгнэлтээр уртасгагч, залгуур, тэжээлийн утаснаас үүдсэн гэж тогтоогдсон аливаа хохирол;
4. Үйлдвэрлэлийн дефектээс болон зориулалтын бус сэлбэг хэрэгсэл суурилуулсан, буруу суурилуулсан, угсарсан, задалснаас үүдэн гарсан хохирол болон тэдгээрийг засварласан аливаа зардал;
5. Үйлдвэрийн баталгаат хугацаанд засварлагдах эсвэл солиулах боломжтой хохирол;
6. Газар хөдлөлтийн улмаас даатгалын зүйлд учирсан хохирол;
7. Ашиглалтын хугацаа заасан эд ангиуд болон туслах, дагалдах материалуудад учирсан хохирол;
8. Даатгуулагчийн өөрийн гэмт хэргийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохирол;
9. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийн зөвшөөрөгдсөн байршил өөрчлөгдсөн, бусдад барьцаалуулах, түрээслүүлэх, зээлдүүлэх, болон ашиглуулах үед гарсан хохирол;
10. Хадгалалтын горим зөрчсөн, урсгал засвар болон зайлшгүй хийгдэх засвар үйлчилгээний ажлыг цаг хугацаанд нь хийгээгүйгээс үүдсэн хохирол;
11. Хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтсэн;
12. Гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэрлэлтийн үед учирсан хохирол /Зөөврийн цахилгаан хэрэгсэлд хамаарахгүй/;
13. Даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлийн байршиж буй байгаль орчинд учирсан хохирол;
14. Гэрээнд заагдаагүй эрсдэл болон бохирдлоос учирсан хохирол;
15. Даатгуулагч, түүний ажилтны сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй үед хийсэн аливаа үйлдлээс үүдсэн болон согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн үйлдлийн улмаас үүссэн болох нь тогтоогдсон аливаа хохирол;
16. Даатгагчтай тохиролцолгүйгээр хохирлын бодит хэмжээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдол;
17. Хууль тогтоомжид заасан бусад.